



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 9/11

Мандалговь

Г

Эрх шилжүүлэх тухай

Т

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2019 онд Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан “Гурвансайхан сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх” ажлын эрхийг Гурвансайхан сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

Хоёр. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчтэй хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн, хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат)-д үүрэг болгосугай.

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн 46.3 дахь заалтыг үндэслэн эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа хөрөнгө оруулалт, ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-т, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488010026